

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ДЭД САЙД О.ЧУЛУУНБАТЫН ХЭЛСЭН ҮГ

Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе! Юуны өмнө энэ арга хэмжээнд урьсан ноён элчин сайд Ван Сяолун танд болон Хятадын элчин сайдын яамны хамт олонд баярлаж байгаагаа илэрхийлье!

Энэ арга хэмжээнд уригдан ирж Хятадын Коммунист Намын Төв Хорооны 3 дугаар бүгд хурлын шийдвэрийн, Ялангуяа Монгол, Хятадын харилцаатай холбогдох ямар нөлөө үзүүлэх талаар сонирхолтой мэдээлэл бодол санаагаа илэрхийлэхээр ирсэн ноён Жао Цижэн танд талархаж байгаагаа илэрхийлье! Монгол, Хятадын хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд маш сайн хөгжиж байгааг та бүхэн бүгд мэдэж байгаа. Ирэх онд Монгол, Хятадын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ой мөн Монгол, Хятадын найрсаг хамтын ажиллагааны гэрээний 20 жилийн ой болно. Яг энэ үед энэхүү хурлыг зохион байгуулж Монгол, Хятадын хоорондох найрамдалт хамтын ажиллагаа, тэр дундаа эдийн засгийн хамтын ажиллагаагаа цаашид хэрхэн хөгжүүлж боловсронгуй болгох талаар ярилцах гэж байгаад би их баяртай байна. Монгол Улс сүүлийн 5, 10 жилийн хугацаанд маш хурдацтай хөгжсөн. Гол шалтгаан нь Хятадын эдийн засгийн том үсрэлт юм. Хятадын эдийн засгийн өсөлт нь манай улсад бий болгож байгаа эрэлт хэрэгцээ гэж би ойлгодог. Хятад улс маань өөрөө дэлхийн хоёр дахь том эдийн засаг болчихсон байгаа.

Тун удахгүй дэлхийн нэг дэхь том эдийн засаг болно гэдэгт бид бас итгэлтэй байдаг. Тэгэхээр энэхүү маш их том боломж, бололцоо манай улсад бий болж байна гэдгийг бид ойлгож байгаа. Энэ бололцоог бид алдаж болохгүй бөгөөд энэхүү бололцоог алдвал биднийг өршөөхгүй болов уу гэж боддог юм. Дөнгөж сая хуралдсан Хятадын Коммунист Намын 3 дугаар бүгд хурлаас Хятадын эдийн засгийг боловсронгуй болгож, өөрчлөлт шинэчлэлийг хийе гэсэн шийдвэрүүд гарсан. Энэ бол ялангуяа бидэнд манай цаашдын хөгжилд том нөлөө

үзүүлнэ гэж бодож байна. Энэ талаар манай уригдан ирсэн зочин мэдээлэх юм байна. Энэ их сонирхолтой болох байх гэж ойлгож байна. Манай хоёр улсын хооронд найрамдалт харилцаа болон эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжиж байгаа ч гэсэн цаашид бидэнд анхаарах зүйлс их байна. Ялангуяа эдийн засаг хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт зэрэг дээр Хятадын талаас маш их гомдол ирдэг.

Энэ бүхнийг энэхүү хурлын үеэр ярилцаж яаж хууль эрх зүйн хувьд, захиргааны хувьд, гэрээ хэлэлцээрийн хувьд, бизнесийн хувьд, хэрхэн яаж арилгах ёстой юм, яаж үргэжлүүлэх ёстой зэрэг бүхий л талаар ярилцах байх гэж бодож байна. Иймд энэ хуралд зөвхөн Засгийн газар, Монгол Улсын ШУА-ийн группээс гадна эдийн засгийн групп болон бизнесийн байгууллагууд оролцож байгаа юм. Тэгэхээр тэдний талаас олон сонирхолтой саналууд ирнэ байх гэж найдаж байна. Ингээд та бүхэнд амжилт хүсье! Уригдаж ирсэн зочиддоо Монголд тавтай морилоорой гэж хүсье!